22	104 <sup>0</sup>	30'	11.67"	48 <sup>0</sup>	17'	31.92 "	49	104 <sup>0</sup>	30'	00.00"	48 <sup>0</sup>	16'	10.00 "
23	104 <sup>0</sup>	30'	11.66"	48 <sup>0</sup>	17'	30.75 "	50	104 <sup>0</sup>	30'	00.00"	48 <sup>0</sup>	17'	00.00 "
24	104 <sup>0</sup>	30'	13.54"	48 <sup>0</sup>	17'	30.72 "	51	104 <sup>0</sup>	29'	36.00"	48 <sup>0</sup>	17'	00.00 "
25	104 <sup>0</sup>	30'	13.52"	48 <sup>0</sup>	17'	32.86 "	52	104 <sup>0</sup>	29'	36.00"	48 <sup>0</sup>	17'	16.00 "
26	104 <sup>0</sup>	30'	06.05"	48 <sup>0</sup>	17'	32.83 "	53	104 <sup>0</sup>	29'	00.00"	48 <sup>0</sup>	17'	16.00 "
27	104 <sup>0</sup>	30'	06.04"	48 <sup>0</sup>	17'	34.38 "							





Зураг 1. “Ар Наймганы дунд хэсэг” нэртэй MV-005028 тоот (1252,6 га) ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн байршлын зураг.

## ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТҮҮХ

Хойд Хэнтийн районы геологийн тогтоцын тухай тойм ойлголт XX зууны эхэн үе буюу Ардын хувьсгал хүртлэх цаг хугацаанд газар зүйн болон геологийн зориулалттай маршрутын судалгаанууд, хувь нийлүүлсэн "Монголор" нийгэмлэгийн алтны шороон ордын эрэл, хайгуул, олборлолтын ажлууд дээр тулгуурлагддаг. Анх XIX зууны сүүлч XX зууны эхэн үеэс эхлэн Н.М.Прежевальский /1870/, Г.Н.Потанин /1876-1899/, В.А.Обручев /1892-

1894/, П.К.Козлов, А.Н.Чернов /1907-1909/ зэрэг Оросын судлаачид газарзүйн, геологийн судалгааны аялал хийсэн.

1892 онд В.А.Обручевын удирдсан экспедиц Хиагтаас Бээжин хүрэх замдаа Монгол орны хойд, төв хэсгийн газарзүйн байдал, уул үүсэх үйл явц болон тэнд тархсан тунамал хурдсын гарал үүслийн талаар дүгнэлт өгч зарим хурдсын нас тогтоох ажлыг хийсэн.

Заамарын алтны хүдрийн зангилааны алтны шороон хуримтлалын талаар нэлээд эртнээс мэдэгдэж байсан ба эртний алт олборлогчдын ашиглаж байсан ухмалын бүдгэрсэн ул мөр Туул голын хөндийн баруун талын өндөр дэнжүүдээр, мөн Баянгол, Цагаан булаг, Урт сайр, Тосонгийн хөндийд үлдсэн байдаг.

1913-1914 онуудад "Монголор" нийгэмлэгийн захиалгаар М.А.Усов, М.К.Корозин, М.А.Молчанов нар Хэнтийн нурууны баруун хэсгийн 1:42000-ны масштабтай геологийн анхны зураг зохиож, алтны үндсэн ордуудыг эртний гранодиоритын формац болон гуравдагчийн өмнөх настай кварцат порфиртой холбоотой ба орчин үеийн голын хурдсанд таатай нөхцөлд, шороон орд үүсэх боломжтой гэсэн дүгнэлт өгсөн.

1909–1920 онуудад хувь нийлүүлсэн "Монголор" нийгэмлэгийн үйл ажиллагаагаар Монголд анх албан ёсны алт олборлолт эхэлсэн гэж үздэг. Уг нийгэмлэг нь Ерөө, Хараа, Бороо, Хүдэр голуудын нутгаар олон тооны алтны ордуудыг бүрэн бус ашиглаж байжээ.

1932 онд Г.Д.Падалка Хойд Хэнтийн алтны эрдэжилт, түүнтэй холбоотой үүссэн ордын талаархи судалгаа хийж нөөцийг нь тоймлон тооцоолон, зарим талбайд дараагийн үе шатны ажлын чиглэлийг тодорхойлсон байна.

Дүүргийн геологийн тогтцын анхны системтэй судалгаа 1940-иад оны сүүлээр эхэлж, В.А.Ботевату ба А.М.Арсентьева нар 1958 онд 1:1 000 000 масштабын геологийн зураг зохиосон.

1946-47 онуудад Н.Е.Невзоров 1:200000-ны масштабын алтны эрэл, геологийн зураглалын ажил хийж, уг талбайд тархсан эртний хурдсыг дунд палеозойн настай грауваккийн сери гэж ялгасан байдаг.

1957-58 онуудад В.Н.Логинов талбайн зүүн хойд талаар 1:200000-ны масштабын эрэл-зураглалын ажил хийсэн байдаг. Энэ ажлаар силур-девоны настай гэсэн грауваккын серийг дотор нь гурван зузаалагт ялгаж, мөн пермийн насны доод вулканоген, дээд терриген ба ангилагдаагүй вулканоген-тунамал гэсэн гурван свитийг ялгасан байна.

1961 онд Ю.П.Ершов, М.И.Горин нарын гүйцэтгэсэн 1:200000-ны масштабтай эрэл зураглалын ажил нь судалгаа хийсэн талбайн хойд хэсгийг хамардаг. Судлаачид грауваккын серийн бүрэлдэхүүнээс гнейс, талстлаг занар, амфиболит, кварцит зэрэг хувирмал чулуулгийг салган протерозойн цаг үед, хувиралд бага зэрэг орсон элсэн чулуу-занарын



хэсгийг нь литологийн найрлагаар нь 6-н зузаалагт ялгаж таамгаар девоны галавт хамруулсан. Гүний чулуулгуудыг протерозойн, девоны, доод пермийн интрузив бүрдлүүдэд ялгасан байна.

1965-67 онуудад А.Кампе тэргүүтэй Германы геологчид хайгуулын талбайг бүхэлд нь хамарсан 1:50000-ны масштабын алтны эрэл, зураглалын ажил хийсэн. Тэдний энэ ажлын үр дүнд грауваккийн серийг дотор нь гурван свитэд ялгаж Н.Е.Невзоровын пермийн гэж ялгасан хурдсаас далайн амьтдын үлдэгдэл анх олж уг хурдсыг дунд-дээд девоны настай болохыг баттай тогтоосон. Алтны хүдэржилт нь герциний үеийн хагарлын нөлөө бүхий жижиг хэмжээний дэл судлын чулуулагтай гарал үүслийн, зүүн хойш чиглэн сунаж тогтсон атираажилтад хүчтэй орсон хувирмал чулуулгийг зүсэж үүссэн кварцын судлуудтай орон зайн хувьд холбоотой гэж үзээд хүдэржилтийн үнэмлэхүй насыг пермь-триас гэж тодорхойлсон байна.

1967 онд Р.А.Хасин нарын зохиосон Монгол улсын 1:1500000-ны масштабтай, геологийн анхны зураг дээр Хойд Хэнтийн өргөгдөлд тархсан эртний хурдсыг доод палеозойн настай “Хараагийн сери” нэрийн доор ялгасан байна. Хараа серийг В.А.Амантов анх удаа Заамарын нуруунд ялгаж, доод буюу занар-хувирмал элсэн чулуу-микрокварцитын, дунд буюу элсэн чулууны, дээд буюу элсэн чулуу-филлит маягийн занарын гэсэн гурван зузаалагт хуваасан байдаг.

1968-1970 онд Д. Бямба, Л. Баатар нар 1:200000 масштабын эрэл-зураглалын ажил хийснээр Хараа серийн хурдсыг хоёр зузаалагт ялгажээ. Интрузив бүрдлүүдийг каледоны цаг үед хамруулан түрүү ба түрүү-дунд палеозойн бүрдлүүдэд ялгасан байна. Эрлийн ажлын үр дүнд алт, төмөр, зэс, мөнгө, гянт болдын илрэлүүд, тэдгээрийн шлих, геохимийн сарнилын хүрээнүүдийг илрүүлсэн. Түрүү-дунд палеозойн интрузив нь алт, ховор металлын эрдэсжилт дагуулдаг гэж үзжээ.

1971 онд 1:200000-ны масштабтай геологи-эрлийн ажлаараа В.М.Якимов, Б.Ламатханов, А.Баатар нар Заамарын нурууны баруун болон баруун-хойд хэсгүүдийг хүдрийн болон шороон алтны хувьд ирээдүйтэй хэмээн үнэлж, нарийвчилсан эрлийн ажил явуулах талбайг ялгаж өгсөн байна.

1973-1975 онд ГУУҮЯ-ны харъяа ГУУҮШИ-ийн дэргэдэх сэдэвчилсэн судалгааны анги Хойт Хэнтийн алтны бүсийн алтны байршлын зүй тогтолын талаар 1:500000-ны масштабтай металлогений судалгаа хийж, Заамарын районы шороон ордуудад таамаг нөөцийг 5.0-7.0 тн гэж тогтоожээ (Т.Семейхан, В.Поздняк).

1979-1981 онуудад Д.Жамцаа нар (3600ф) Заамарын нурууны районд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил хийж дээрх нурууны төвийн хэсэгт Заамар свит

(В.М.Якимов, 1972) буюу Хараа серийн доод зузаалагтай (Р.А.Хасин,1967) дүйх венд-түрүү кембрийн Мандал серийн метаморфжсон элсэн чулуу, занарын зузаалаг ялгасан байна. Мөн доод палеозойн Хараа серийг 2 зузаалагт хувааж үзэхдээ доод хэсэгт нь В.М.Якимов нарын ялгасан Дархан свитийн шохойн чулуу, гантигийн үеүд бүхий хурдсыг хамааруулж, Авзага свитэд ялгасан (Заамарын нуруу) хурдсыг доод пермийн хурдас гэж үзсэн байна. Бусад ангилалын хувьд В.М.Якимов нарын ангиллыг мөрдлөг болгосон байна. Д.Жамцаа, В.Довжид нарын ажлаар алтны хүдрийн 17, шороон ордын 10 илрэл тогтоож, шороон ордын хэтийн төлөвийг 15,4 тн гэж үзсэн нь цаашдын хайгуулын ажлууд явуулах үндэслэл болсон байна.

1981 оноос эхлэн Дарханы Геологийн экспедиц Заамарын алтны хүдрийн зангилаанд алтны шороон ордын эрэл ба хайгуулын ажлыг явуулсны үр дүнд Хайлааст, Туул, Тосон зэрэг 20 орчим алтны шороон ордыг илрүүлэн тогтоосон байна.

1981 онд Оросын геологийн экспедиц Туул голын хөндий болон түүнд цутгагч хөндийнүүдийн адагт эрлийн ажлыг цохилтот өрөмдлөгийн аргаар гүйцэтгэн үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий 14 шороон ордыг нээсэн. Энэ ажлын үр дүнд Монголд хамгийн том ирээдүй бүхий алтжилтийн бүсийг тогтоож, Заамарын дүүргийн алтны шороон ордуудын хэмжээнд алтны таамаг нөөцийг 74.9 тн гэж үнэлсэн (В.Довжид, А.Н.Кирсанов нар, 1984) байна.

1982 оноос Төвийн геологийн экспедицийн Жанчивлангийн хайгуулын анги Заамарын дүүргийн Хайлааст, Ар Наймган зэрэг томоохон хөндийнүүдэд эрэл-хайгуулын ажлыг эхлүүлсэн байна.

1983 оноос Дарханы геологийн экспедиц Хайлаастын ордын хайгуулыг үргэлжлүүлэн гүйцэтгэж ордын алтны нөөцийг 6.0 тн-оор тогтоон үйлдвэрлэлд шилжүүлсэн байна.

1983 онд Д.И.Портянников, С.Цэрэн-Очир нар Хойд Хэнтийн алтны бүсийн баруун урд хэсгийн шороон ордын хэтийн төлөвийн үнэлгээний тайлбар бичиг зохиожээ.

1983-1985 онд Туул голын хөндийд Дарханы геологийн экспедиц, ГУУУЯ-ны харьяа Төвийн геологийн экспедицийн Жанчивлангийн анги Бага Хайлааст, Дунд голуудын хооронд эрэл хайгуулын ажлыг гүйцэтгэсэн.

1984 онд ЭГЦЭ-ийн чичирхийлэл судлалын ангиас Заамарын хөндийд нүүрсний цогцолбор судалгаа хийж, 65-140 м гүнд нүүрс агуулагч хурдас, Ар боржингийн алтны илрэлийг илрүүлсэн байна.

1986 онд А.Л.Шпильков нар, 1988 онд П.Н.Ивушкин нар 1:50000-ын масштабтай агаарын соронзон, агаарын цахилгаан соронзон, агаарын гаммаспектрометрийн гэсэн аргачлалаар илэрсэн гажлуудын хэмжилтийг газрын гадаргууд маршрутын шалгалтаар явуулсан бөгөөд



талбайг бараг бүхэлд нь хамарсан байна. Энэ ажлын үр дүнгээр 2 тайлан зохиогдож геофизик соронзон орны шинж чанарын талаархи бүрэн тодорхойлолт өгчээ. Энэхүү мэдээллийг ашиглан районы геологийн тогтцыг нилээд нарийвчилж, тектоник, металлогены томоохон бүсийн ангиллуудын заагийг шинээр тогтоож, алтны хүдэржилт нь тохролын бүс дэх девоны боржинтой орон зайн болон гарал үүслийн холбоотой, түрүү мезозойн боржингийн бүрдлүүд нь зөвхөн ховор металлын хүдэржилттэй холбоотой болохыг тогтоож, Заамар, Аргал, Улаан хадны алтжилт, Угтаал-Цайдамын ховор металлын хэтийн төлөв бүхий талбайнуудыг ялгасан байна.

Мөн 1986 онд Н.Г.Эйдельман, О.Наранцэцэг, Б.Пүрэвсүрэн нар /4597ф/, Зөвлөлтийн геологийн экспедиц, Монгол-Зөвлөлтийн хамтарсан Дарханы экспедицүүд Заамарын хүдрийн зангилгаанд 1:50000-ын масштабын геологийн зураглалын ажлыг гүйцэтгэн шлих, геохимийн түрүүлсэн эрлийн ажлыг хийж, түүний үр дүнд илэрсэн олон тооны шлих, геохимийн сарнилын хүрээ илрүүлж, Заамарын хүдрийн зангилгаа алтны шороон болон хүдрийн илэрцүүдийн үнэлгээг хийж, цаашдын эрлийн ажлын болон судалгаа шинжилгээний ажлын үндсэн чиглэлийг тодорхойлсон байна.

1988 онд В.Г.Журавлев, Н.И.Миклашев нар “БНМАУ-д 1988-1990 ба 2000 он хүртэл алтны шороон ба үндсэн ордын хайгуул явуулах хөтөлбөр” зохиож, энэхүү ажлын үр дүнд геологи, металлогены асуудлаар олон тооны шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний ажил хэвлэгдсэн.

1986-1989 онуудад Н.Н.Кузнецов, Б.Пүрэвсүрэн нар 1:50000-ын ерөнхий эрэл-зураглалын ажлын үр дүнд геологийн тогтоцыг нарийвчлан ангилалыг хийхдээ Хараагийн серийн доод хэсэг болох Заамар свит нь гадаргууд илрэхгүй учир Хараа серийн дээд свитийн 2 зузаалгийг Хараа серийн доод, дээд зузаалаг гэж ялгасан байна.

1991 онд П.Батчулуун нар Заамарын алтны хүдэржилтийн зангилааны өмнөд хэсэгт хийсэн 1:50000-ны масштабтай зураглал /4792ф/, ерөнхий эрлийн ажлаар районы геологийн тогтцыг нарийвчлан зурагласан байна.

1991-1994 онуудад С.Төмөр нар 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил хийсний үр дүнд алтны цөөн тооны, жижиг хэмжээтэй, ядуувтар агуулга бүхий үндсэн болоод шороон илрэл, эрдэсжсэн цэгүүдийг олж тогтоосон байна.

1996-1998 онуудад Б.Бадарч, Г.Сэнгэдорж нар 1:50000-ын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил хийж, палеозой, мезозой, кайнозойн хурдсуудыг ялгаж, насыг нь амьтан, ургамлын үлдэгдэл, үнэмлэхүй нас болон бусад баримтуудаар баталгаажуулсан байна.

Сэдэвчилсэн судалгааны ажлуудаар 1982-1985 онд Н.Я.Шаболовская, Т.Пүрэвдорж, Г.Дэжидмаа нар "Хойт Хэнтийн металлогений бүсийн баруун өмнөд хэсгийн том масштабын металлогений судалгаа ба нөлөөлөгч хүчин зүйл" хэмээх сэдвээр шороон орд ба

үндсэн эх үүсвэрийн хоорондын холбоо, бүрэлдэх нөхцлийг тогтоох судалгаа хийсэн. Олон судлаачид Туулын голын хөндий, түүний цутгал амуудад голын, гол-хормойн, гол-нуурын, хажуу-хормойн гаралтай плиоцен, плейстоцений хурдсуудын стратиграфийн ангиллыг хийсэн байна (Болотова,1966; Поздний кайнозой Монголии, 1989; Девяткин, 1981, 2004; Хосбаяр, 2006).

Ч.Төмөрчөдөр нар (2017) Заамарын дүүрэгт Туулын голын хөндийд мезозой-кайнозойн хурдсын нарийвчилсан судалгааг хийж, доод цэрдийн Хөхтээг, дээд цэрд палеогений Цагаанбулаг, доод миоцений Алим, дээд плиоцений Хайлааст формацуудын болон доод-дунд плейстоцен, дунд плейстоцен, дээд плейстоцен, дээд плейстоцен-голоцен, голоцены сэвсгэр хурдсыг ангилжээ.




## СТРАТИГРАФИ

Тус ашиглалтын талбайд тархсан хурдас чулуулгийн бичиглэлийг хийхдээ хуучин нутгийн стратиграфийн нэгж болох сери, свитүүдийг одоо мөрдөж байгаа “Монголын литостратиграфийн кодекс” (2016) дагуу групп, формац, мэмбэр гэсэн нэрээр өөрчилж бичиглэв.







Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Ар Наймганы дунд хэсэг” нэртэй MV-005028 тоот (1252,6 га) ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд В.М.Якимов нар (1972) 1:200 000-ны масштабтай геологийн зураглалын ажлаараа дээд протерозойн Заамар формац болон дунд кембрийн Хараа групп, дөрөвдөгчийн хурдас, дунд палеозойн интрузив ялгасан бол (Зураг 2), Д.Жамцаа, В.Довжид нар (1981, 3600ф) 1:50 000 масштабтай геологийн зураг ерөнхий эрлийн ажлаараа венд-кембрийн хувирмал чулуулаг, доод палеозойн Хараа группын хурдас, дээд дөрөвдөгч, орчин үеийн сэвсгэр хурдас, түрүү палеозойн гүний чулуулгийг нарийвчлан ангилсан байна (Зураг 3).

Л.Е.Эйдельман, О.Наранцэцэг нарын (4597ф) Заамарын алтны хүдэржилтийн зангилааны өмнөд хэсэгт хийсэн 1:50 000 масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил нь “Ар Наймганы дунд хэсэг” нэртэй MV-005028 тоот (1252,6 га) ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн зүүн талыг хамрах ба энд дунд кембри-доод ордовикийн настай Заамар формац, дунд-дээд дөрөвдөгчийн алюви-пролювийн, дээд дөрөвдөгчийн алюви-пролювийн хурдас болон дунд-хожуу ордовикийн Бороогол бүрдлийн интрузив чулуулгийг ялгажээ (Зураг 4). 1994 онд П.Батчулуун нарын (4792ф) явуулсан 1:50 000-ны масштабтай геологийн зураглалын ажил нь тус судалгааны талбайг бүрэн хамарсан бөгөөд дунд кембри-доод ордовикийн Хараа группын дээд мэмбэр, дунд-дээд дөрөвдөгч, дээд дөрөвдөгч-орчин үеийн хурдас, Бороогол бүрдлийн интрузивыг зурагласан байдаг (Зураг 5). Хамгийн сүүлд Г.Дэжидмаа нар (2004, 5733ф) Улсын геологийн 1:200 000-ны масштабтай зурагтаа тус талбайд Хараа группыг дотор нь Заамар, Доргонт, Ширгүү формацуудад ангилж, тус талбайд Заамар формацыг зураглаж, насыг хэвээр авсан байна (Зураг 6).

“Монгол майнинг энд эксплорэйшн” ХХК-ны геологичид “Ар Наймганы дунд хэсэг” нэртэй MV-005028 тоот (1252,6 га) ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай ордын 1:25 000 масштабтай геологийн зурагтаа Заамар формацын доод ба дунд мэмбэрийн занар, метавулканитаар ангилжээ (Зураг 7).




Зураг 2. “Ар Наймганы дунд хэсэг” нэртэй MV-005028 тоот (1252,6 га) ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай орчмын 1:200 000 масштабтай геологийн зураг (ГУФ № 1960)

	Дөрөвдөгчийн хурдас. Делюви, пролювийн гаралтай бул чулуу, хайрга, хайрганцар, сайрга, элс, элсэнцэр, шавар, шавранцар.
	Дунд-дээд триас. Авзага формац. Конгломерат, элсэн чулуу, алевролит
	Хараа групп. Дээд мэмбэр. Занар, шаварлаг занар, карбонатлаг элсэн чулуу.
	Доод мэмбэр. Элсэн чулуу, карбонатлаг занар, жижиг ширхэгтэй шаварлаг конгломерат.
	Дээд протерозойн Заамар формац. Эпидот-амфибол, эпидот-биотиттой, кварц-серицит-актинолиттой занар, карбонатжсан, метаморфжсон элсэн чулуу.
	Дунд палеозойн интрузив комплекс. Лейкократ, биотиттой, жижиг мөхлөгтэй порфирлог гранит.







Зураг 4. “Ар Наймганы дунд хэсэг” нэртэй MV-005028 тоот (1252,6 га) ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай орчмын 1:50 000 масштабтай геологийн зураг (ГУФ № 4597)

а Q<sub>IV</sub>

**Орчин үеийн хурдас.** Гольдрол татмын аллювийн хайрга, элс, шавар, нуурын шавар, аллюв-пролювийн элсэнцэр, шавранцар, хайрга, хайрганцар, элс. Дунд-дээд дөрөвдөгч. Аллюв-пролювийн хайрга, хайранцар, элс, шавранцар.

дp Q<sub>IV-IV</sub>

**Заамар формац.**

E<sub>2</sub> Q<sub>1</sub> m<sub>1</sub>  
E<sub>2</sub> Q<sub>1</sub> m<sub>2</sub>  
Заамар формац  
ca 177m


Дээд мэмбэр. Элсэн чулуу, филлитүүд, флиш маягийн үелэл (>1000м)  
Доод мэмбэр. Нарийн үелэг элсэн чулуу, элсэн чулуу, филлитийн үелэл (1870м)

г-г<sub>1</sub> Q<sub>1</sub> δ  
г-г<sub>1</sub> Q<sub>1</sub> vδ

**Бороогол бүрдэл.**

II-дунд ширхэгтэй заримдаа шигтгээлэг боржин, боржин диорит, дэл судлууд, жижиг ширхэгтэй боржин, аплит, диорит-порфир, диабаз-порфир, боржин-диорит, кварцын судал  
I фаз-диорит (δ), габбро-диорит (vδ), габбро, пироксенит





Зураг 5. “Ар Наймганы дунд хэсэг” нэртэй MV-005028 тоот (1252,6 га) ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай орчмын 1:50 000 масштабтай геологийн зураг (ГУФ № 4792)

$\epsilon_2-O_3ch$

Дунд кембри-доод ордовик. Хараа групп. Хар ногоон, ногоон саарал өнгөтэй бага зэрэг роговикжсон элсэн чулуу, ногоон саарал шаварлаг занар, тэдгээрийн ээлжилсэн үелэл

$\gamma_2O_2-3$


Дунд дээд ордовик. Бороогол бүрдэл.

$\delta_2O_2-3$

II фаз. Ягаавтар саарал өнгийн жижиг, дунд ширхэгтэй хааяа порфир маягийн биотиттой гранит, гранодиорит.

I фаз-диорит ( $\delta$ ), габбро-диорит ( $\nu\delta$ ), габбро, пироксенит






Зураг 6. “Ар Наймганы дунд хэсэг” нэртэй MV-005028 тоот (1252,6 га) ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай орчмын 1:200 000 масштабтай геологийн зураг (МУ-ын 1:200 000 масштабын геологийн ижс бүрдэл зураг, 5733, UGZ-200)

- dpQ<sub>1-2</sub> **Дельви-пролювийн хурдас.** Элс, шавар элсэнцэр, шавранцар, хэмхдэс  
 Хуурай хөндий аллюви-пролювийн гаралтай элс ба хайрганы үетэй шавар, шавранцар, хайрганцар, элс, Татмын дээрхи хоёрдугаар ба түүнээс өндөр дэнжүүдийн аллювийн гаралтай ба элсэрхэг-шаварлаг дүүргэгчтэй хайрга, хайрганцар.
  - Q<sub>1</sub>
- 
- Х А Р А А Г Р У П П**  
B<sub>1</sub>-O<sub>1</sub>af **Шаргуу формацийн Дорголт** Занаржсан шохойлог элэжин, шаварлаг болон цахиурлаг-гялтгануурт занарын хэмнэлт үелэл бүхий ногоон саарал ба саарал онготой хурдас. Хаяга алевролитын үе ба мшил тохиолддог. Занар зүсэлтийн 30-50 хувийг эзэлнэ
  - B<sub>2</sub>-O<sub>1</sub>af **Шаргуу формацийн Дорголт** Ногоовтор саарал онготой занаржсан элэжин, шохойлог элэжин зонхилсон хурдас. 10-20 хувийг шаварлаг болон цахиурлаг-шаварлаг занар, алевролит, ховроор гравелитын үеүд эзэлдэг. Дүүргэгчийн 5-30 хувь нь карбонат эрдсүүд. Карбонатын хэмхдэс ч тохиолддог
  - B<sub>3</sub>-O<sub>1</sub>af **Шаргуу формацийн Дорголт** Нарийн үелэлт занар мэмбэр. 1-2 м-с 0.1-0.5 м зузаан метилэлэжин ба металевролитын янз бүрийн хэмнэлт үелэл. Метилэлэжин, металевролит нь метаморфжижэ элидот-циозит-хлорит, мусковит-элидот-циозит-хлорит, амфибол-серпичит-хлорит-элидот-циозитот занарт хувирсан
  - B<sub>4</sub>-O<sub>1</sub>af **Шаргуу формацийн Дорголт** Метавулканит мэмбэр. Дундлаг-суурилаг вулканитаар үүссэн хар ногоон, хар ба цэнхэрдүү ногоон онготой актинолит-плагиоклаз-элидот-циозитот занар
  - B<sub>5</sub>-O<sub>1</sub>af **Шаргуу формацийн Дорголт** Нарийн-бүдүүн үелэлт занар мэмбэр. Кварц-актинолитот, кварц-серпичит-актинолитот, элидот-актинолитот занар болон серпичит-элидот-циозит-хлорит, мусковит-элидот-циозит-хлорит, серпичит-актинолит-элидотот занарын нарийн болон бүдүүн үелэлт салаавчлал. Нарийн үелэлд 1-10 м зузаан, бүдүүн үелэлд 0,5-1 м-ээс 5-40 м зузаан хэмнэлүүд тохиолддог





Зураг 7. “Ар Наймганы дунд хэсэг” нэртэй MV-005028 тоот (1252,6 га) ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай ордын 1:25 000 масштабтай геологийн зураг

### ***Хараа групп. Заамар формац.***

***Нэрийн гарал:*** В.М.Якимов нар Заамарын нуруунд анх ялгасан.

***Судалгааны түүх:*** 1920-иод оны эхээр Н.А.Усов, С.Н.Алексеичик зэрэг судлаачдын Хангай-Хэнтийн бүсэд “Бархын свит” буюу грауваккын формац гэж ялгасан хурдсыг Хойд Хэнтийн бүсэд анх В.А.Амантов, Р.А.Хасин нар (1968) доод палеозойн “Хараагийн сери” гэж нэрлэн ногоон занар-элсэн чулуу-микрокварцит, элсэн чулуу, элсэн чулуу-шаварлаг занарын гэсэн гурван зузаалагт ялгасан байдаг. Л.Баатар (1971ф) зураглалын ажлын явцад Заамар свитэд ялгаж, дээд протерозойн настай гэж үзжээ. 1972 онд В.И.Якимов Заамарын нурууны орчимд хийсэн 1:200000-ны масштабын зураглалын ажлаараа В.А.Амантовын ялгасан Хараагийн серийн доод зузаалгийг түүний бүрэлдэхүүнээс салган протерозойн настай Заамарын свитэд ялгасан. Дараа нь В.М.Якимов (1977) Хараа серийг Заамар, Дархан свитүүд болон жинхэнэ Хараа сери гэж 3 хуваажээ. Хожуу протерозойн Заамар свит нь Р.А.Хасин нарын Заамарын нуруунд ялгасан Хараа серийн доод ногоон занарын зузаалаг юм. Уг зузаалгийн дээр хожуу протерозой-түрүү кембрийн Дархан свитыг ялгаж, Хараа серийн хурдсаар нийцлэгээр хучигдаж байна гэж үзжээ.

Сүүлийн үеийн судалгаагаар (Бямба нар 1988, Төмөртоогоо, Бямба нар 1990) уг формацыг Хараа группын хамгийн доод зузаалагт хамааруулсан байдаг. Л.Е.Эйдельман, О.Наранцэцэг нар (1986, 4597ф) дунд кембри-доод ордовикийн насанд хамааруулж үзсэн. Монгол орны геологийн судалгааны региональ түвшингийн хувьд Хараа группын хурдас нь Баянхонгорын бүсийн “Загийн сери”, Баруун Монголын “Уулын Алтайн сери”- тэй дүйнэ. Г.Дэжидмаа нар (5733ф) 1:200000-ны масштабтай Улсын геологийн зурагт дунд кембри-доод ордовикийн Хараа группын доод талд Заамар формацыг ялгаж, дотор нь нарийн-бүдүүн үелэлт занар, метавулканит мэмбэр, нарийн үелэлт занар гэсэн 3 мэмбэрт хуваасан байна.

***Талбайн тархалт:*** Төв аймгийн Баянцогт, Угтаалцайдам, Заамар, Баянчандмань, Батсүмбэр, Лүн, Өндөрширээт, Эрдэнэсант, Сэлэнгэ аймгийн Түнхэл сумдын нутагт өргөн тархалттай. Хурдас нь Заамарын антиклиналь-гүдэнгийн төвөн хэсэгт байрлана. Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Ар Наймганы дунд хэсэг” нэртэй MV-005028 тоот (1252,6 га) ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд голын хөндийгөөс бусад газраар талбайн ихэнхийг эзлэн өргөн тархсан байна.

***Илэрц:*** Эрчимтэй хэрчигдсэн дунд зэргийн уулсын гадаргуу үүсгэх ба уулын хяр, хамар хэсгээр илэрнэ. Заамар формацын хурдас нь Заамарын нурууны төвөн структурын төвийн хэсгээр илэрсэн зүүн урагш хөнтөрсөн антиклиналийн гол болдог.



**Агаар сансрын зурагт тайлагдах байдал:** Агаарын зурагт бусад насны хурдсаас ялгарах онцлог байхгүй, эрчимтэй хэрчигдсэн уулын хажуу ирмэгээр мөчирлөг зурагламж, цайвар саарал дэвсгэр өнгө үзүүлнэ. Заамарын нурууны төвөн өргөгдлийн хэсэгт Заамар формацын хурдсууд нь янз бүрийн хэмжээний изоклиналь, хөнтрүү атриажилд орж, тасрал эвдрэлээр хэрчигдсэн маш нийлмэл тогтоцтой болсон байдаг.

**Стратиграфийн хил:** Дархан формац, Доргонт формацын хурдастай хагарлаар хиллэж, триасын Авзага, доод цэрдийн Манлай формацын хурдсаар болон дунд-дээд плейстоцены аллюви-пролювийн элс, хайрганы үетэй шавранцар, хайрга, хайрганцар, элсээр хучигдана. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн орчимд дунд-хожуу ордовикийн Бороогол бүрдлийн дунд том мөхлөгт биотиттой порфир маягийн боржин, боржин диорит, габброгоор зүсэгдэнэ.

**Литологи:** Энэ формацын хурдас эпидот-амфиболитын фацын метаморф хувиралд өртсөн кварц-хээрийн жоншт-серицитийн, кварц-серицит-эпидотын, эпидот-актинолитын, кварц-актинолитын бүтэцтэй талст занаруудаас бүрдэх ба чулуулагнь березитжих, пропицитжих төрлийн хоёрдогч хувиралд орсон нь байдаг. Ийм төрлийн хувиралд орсон чулуулаг алтны эрдэсжилттэй байх бөгөөд алтны агуулга ганц нэг сорьцод 1.8 г/т хүрнэ. Формацын зүсэлтийн дунд хэсэгт суурилаг найрлага бүхий метавулканитууд дайралдана. Заамарын хурдсуудыг зааглагч тулгуур үеийг бүрдүүлэгч дундлаг, суурилаг эффүзивүүд нь амфиболит болтол хувирч өөрчлөгдсөн байдаг. Амфиболит нь цул нягт текстуртэй, заримдаа шигтгээ маягийн тогтоцтой, хар ногоон, ногоон саарал, хааяа цайвар саарал өнгөтэй. Ногоон занарын фацын чулуулгийн хувирлын зэрэг нь төвөн өргөгдлийн төвөөс зах хэсэг рүүгээ аажмаар буурдаг.

**Дотоод ангилал:** Заамар формацын хурдсыг метаморф хувирлын зэрэг болон литологийн найрлагаар нь хувирмал галт уулын чулуулгийн үеэр зааглагдах доод, дунд ба дээд гэсэн 3 мэмбэрт хуваана.

**Нарийн-бүдүүн үелэлт занарын доод мэмбэр ( $E_2-O_1zm_1$ ).** Заамар формацын хурдсууд нь дотоод бүтэц болон тогтцоороо хоорондоо бараг ялгарахгүй боловч доод мэмбэрийн хурдас нь эпидот-амфиболитийн фацийн гүн метаморфизмд өртөж, хар гялтганууртай занар, амфиболитийн бүлгийн кварц-актинолит-серицит-цоизитын төрлийн хувиралд орсон метаэлсэнчулуу-метаалевролит үелэлээс тогтоно. Голчлон кварц-актинолитот, кварц-серицит-актинолитот, эпидот-актинолитот, серицит-эпидот-цоизит-хлоритот, мусковит-эпидот-цоизит-хлоритот, серицит-актинолит-эпидотот занарт хувирсан. Энэ мэмбэрийн ( $E_2-O_1zm_1$ ) хурдас нь Заамарын нурууны бүнхэр хэлбэрийн төвөн өргөгдлийн төвийн хэсгийн түүний хоёр жигүүрийг бүрдүүлнэ. Хурдас нь ерөнхийдөө зүүн хойш чиглэсэн суналтай, 60-

70<sup>0</sup>-ын уналын өнцөгтэй, зарим газартаа I, II зэргийн изоклиналт болон хөнтрүү атираажилтанд орсноос гадна тасралт эвдрэлээр хэрчигдэж, суналын чиглэл нь өөрчлөгдөн, уналын өнцөг ихсэх /80<sup>0</sup>/ буюу багасах /45<sup>0</sup>/ зэрэг маш нийлмэл тогтоцтой болсон байдаг.

Доод мэмбэрийн хурдсын зузаан 1400-1900м хүрдэг.

*Метавулканитын дунд мэмбэр (E<sub>2</sub>-O<sub>1</sub>zm<sub>2</sub>).* Хурдас нь дүүргийн зүүн хэсгээс баруун урагш сунаж тогтоно. Хурдас нь дундуураа Ар наймганы алтны шороон ордын хөндийгөөр хуваагдана. Энэ мэмбэрийн хурдас нь кварц, актинолит, эпидот-цоизитот зэрэг эрдсүүдийг зонхилон агуулсан ногоовтор саарал, цайвар саарал болон шаргал туяатай ногоон саарал өнгөтэй, зурваслаг текстуртэй талстлаг занарууд буюу метаэлсэн чулуунууд, найрлагад нь серицит, хлорит, эпидот-цоизит ба биотит зонхилох филлит маягийн тогтоцтой ногоовтор, харавтар саарал өнгийн занарууд буюу метаалевролитууд, хар ногоон, ногоон саарал, заримдаа цайвар саарал өнгөтэй, нягт текстуртэй метаэффүзивүүдээс тогтоно. Суурилаг вулканитаар үүссэн хар, хар ногоон, ногоон, цэнхэрдүү ногоон өнгөтэй актинолит-плагиоклаз-эпидот-цоизитот занараас тогтоно.

*Нарийн үелэлт занарын дээд мэмбэр (E<sub>2</sub>-O<sub>1</sub>zm<sub>3</sub>)* нь хэмлэг байдлаар салаавчилсан тогтоцтой, найрлагад нь кварц, актинолит, эпидот-цоизит зэрэг эрдсийг зонхилон агуулсан ногоовтор саарал, шаргал туяатай ногоон саарал өнгөтэй зурваслаг текстуртэй талстлаг занарууд буюу метаэлсжин, найрлагад нь серицит, хлорит, эпидот-цоизит ба биотит зонхилох филлит маягийн тогтоцтой ногоовтор, харавтар саарал өнгийн занарууд буюу мета-алевролитууд, хар ногоон, ногоон саарал, заримдаа цайвар саарал өнгөтэй, цул нягт текстуртэй мета-эффүзивүүдээс тогтоно. 1-2 мм-с 0.1-0.5 м зузаантай мета элсэнчулуу ба метаалевролитын янз бүрийн хэмнэлт үелэл нь метаморфжиж, эпидот-цоизит-хлорит, мусковит-эпидот-цоизит-хлорит, амфибол-серицит-хлорит-эпидот-цоизитот занарт хувирсан. Метаморфизмд сул автсан ба бараг хувираагүй элсэнчулуу алевролитын цемент нь актинолит, эпидот, хлорит, серицит, хэмхдэс нь кварц, хээрийн жонш, боржин, занараас тогтоно.

**Зузаан:** Дунджаар 2800-3000м зузаантай.

**Палеонтологийн шинж:** Организмын үлдэгдэл олдоогүй тул насыг нь Заг болон Уулын-Алтай группын хурдсуудтай харьцуулан дунд кембри-доод ордовикийн настай гэж үздэг.



### *Дөрөвдөгчийн хурдас.*

Дөрөвдөгчийн хурдас Туулын хөндийд өргөн хүрээтэй үүсч тархсан ба дотор нь плейстоцен, плейстоцен-голоцен ба голоцен (“Улсын геологийн зураг-200” төсөл) гэж 3 хуваана. Голоцен ба плейстоцений хурдас алт агуулах боловч алтны агуулга нь хэт ядуу, маш сарнимал тархалттай байдаг байна. Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Ар Наймганы дунд хэсэг” нэртэй MV-005028 тоот (1252,6 га) ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд Ар Наймганы хөндий, түүний салбаруудыг дагаж дунд-дээд плейстоцен ( $Q_1$ ), голоцений ( $Q_2$ ) алюви-пролювийн хурдас нь тархана.

### *Дунд-дээд плейстоцений хурдас (ар $Q_1$ )*

Туулын татам дээрх 2-5м өндөр нэгдүгээр дэнж, 10-20м хоёрдугаар дэнж буюу цутгалуудын намхан дэнжид өргөн тархсан гол төлөв алювиаль-пролювиаль гаралтай хурдсыг плейстоценд ялгадаг. Туул голын баруун, зүүн дэнж, Ар наймганы хөндийн орчим энэ насны хурдас нь тархсан байна.

Нэгдүгээр дэнжийн хурдас нь алюви-пролювийн (ар) гаралтай элс, саарал өнгийн хайрганы үетэй, шавранцар, хайрганцар агуулсан элсэрхэг хурдсаас бүрдэнэ, зузаан нь 0.8-10.4 м байдаг. Хоёрдугаар ( $a_1$ ) ба түүнээс өндөр дэнжүүдэд ( $a_2$ ) хурдас нь аллювийн гаралтай элсэрхэг-шаварлаг дүүргэгчтэй хайрга, хайрганцар хурдсаас бүрэлдэнэ.

Уулын хажуу болон хормой хэсгээр делювийн, делюви-пролювийн, делюви-колловийн (dp) гаралтай, янз бүрийн хэмжээтэй хэмхдэс агуулсан шавранцар, элсэнцэр, шавар, дайрга, үйрмэг агуулсан элсэрхэг-шаварлаг хурдас тархана.

Хойт Хэнтийд Толгойтын голын нэг цутгал болох Намагт хоолойн нэгдүгээр дэнжийн хурдсын насыг *Mammutus primugenus* (Blum)-ийн үлдэгдлээр дээд плейстоцены настай гэж үзжээ (Төмөрчөдөр, 2012). Энд дээд плейстоцены аллювиаль хурдас нь нэгдүгээр дэнжийн ба хоёрдугаар дэнжийн гольдролын болон татмын фациас бүрдэх бөгөөд баялаг алт агуулдаг бөгөөд гольдролын хурдас нь сайн, дунд, мөлийсөн хайрга, хайрганцраас голлон бүрдэж дотроо элс, элсэнцэр, шаврын мэшилүүдийг агуулна. Хурдас нь саарал өнгөтэй, мөлгөржилд өртөөгүй чулуу элбэг байдгаараа онцлогтой. Туул голын цутгалууд, хөндийд дээд плейстоцены хурдсанд том хэмжээтэй хайрга, бул чулуу их тохиолдоно. Холчийн хөндий, Ар хөндий зэрэг өргөн цутгалуудад дээд плейстоцены хурдас нь шаварлаг ихтэй аллювиаль-пролювиаль гаралтай байх ба зүсэлтийн дээд хэсэгтээ элс, хайрганцар, хайрганы үеүдтэй, саарал өнгийн шавранцараас бүрдэнэ. Шавранцар дотор нь мөлгөржөөгүй элсэн чулуу,

занарын үйртэс ч тохиолдоно. Дээд плейстоцены хурдсын нийт зузаан нь 8 - 12 метрээс 20 - 30 м хүрдэг байна.

### ***Голоцен (Q<sub>2</sub>).***

Орчин үеийн хурдас нь гарал үүслээрээ алювийн, алюви-пролюви болон нуурын холилдмол гаралтай, сайн ялгагдаагүй нийлмэл найрлагатай байдаг.

Алювийн гаралтай хуримтлал нь Туул, Хар бух, Нарийн гол болон тэдний цутгал голуудын татам, гольдролыг дүүргэх гольдролын татмын фацаас тогтох саарал өнгийн хурдас юм. Гольдролын фаци нь элс, шавар, шавранцар, хайрганцрын үе, линз бүхий сайн мөлгөржсөнөөс өнцөглөсөн хүртэлх хайргархаг хурдсаас тогтоно. Хайргыг дүүргэгч элсэрхэг хурдсын нэг онцлог нь плейстоценыг бодвол мөхлөгийн хэмжээгээрээ томорсон байна. Хэмхдэс материалын петрографийн найрлагад орон нутгийн чулуулаг (занар, мета элсэн чулуу, боржин) голлон оролцдог, хайрганы 60-70%, элсний 15-20% нь занар, мета элсэн чулуу байна. Хурдсын зузаан нь Туулын хөндийд 2.5-7.0 м байхад доош суусан Заамарын хөндийн хэсэг, Хар бухын голд 16-18 м хүрнэ. Гольдролын фацид орчин үеийн шороон орд агуулагдана.

Энэхүү гольдролын фацийн хурдас нь татмын фацаар хучигдана.

Татмын фаци шар хүрэн, хүрэн саарал, саарал өнгийн шавранцар, лаг шавар, элсэнцэр, элс үйрмэг, үйртэс хайрга зэргээс бүрдэнэ, зузаан нь 0.0-3.0 м орчим, Заамарын хөндийн доод хэсгээр 1.0-12.0 м хүрнэ. Алювийн хурдсын нийт зузаан нь 30.0 м болдог.

### ***ГҮНИЙ ЧУЛУУЛАГ***

“Ар Наймганы дунд хэсэг” нэртэй MV-005028 тоот (1252,6 га) ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай орчимд болон Заамарын антиклиналь гүдэнгийн төвөн хэсэгт Заамар бүрдлийн чулуулаг тархана.

#### ***Доод силур Заамар бүрдэл ( $v_1S_{1z}$ , $\delta_1S_{1z}$ , $\gamma_2S_{1z}$ )***

Тухайн дүүрэгт үүсч тархсан хамгийн эртний настай гүний чулуулаг. Энэ нь бусад насны гүний чулуулагтай харьцуулахад илүү өргөн тархалттай бөгөөд талбайн зүүн, зүүн урд мөн баруун урд, төв хэсгээр илэрнэ.

***Литологи, ангилал:*** Заамар бүрдлийн гүний чулуулаг нь хоёр фазад хуваагдах бөгөөд I фаз ( $v_1S_{1z}$ ,  $\delta_1S_{1z}$ ) нь шүлтлэгдүү найрлагатай габбро, габбро-диорит, диоритуудаас бүрдэх ба ихэвчлэн 2 фазынхаа ( $\gamma_2S_{1z}$ ) боржингуудын хил заагт, заримдаа тэдгээрийн дотор үлдэгдэл, жижиг биет байдлаар илэрнэ. Харин 2-р фаз ( $\gamma_2S_{1z}$ ) нь шүлтлэгдүү найрлагатай дунд



ширхэгтэй, заримдаа шигтгээлэг боржин, лейкоборжин, боржиндиоритоос бүрдэх бөгөөд гүний биетүүдийн хил зааг орчмоор жижиг ширхэгтэй боржин тохиолдоно.

Эдгээр нь өөр хоорондоо фазын аажим шилжилттэй бөгөөд талбайн хэмжээнд янз бүрийн найрлагатай, олон чиглэлд сунасан тогтоцтой, дэл, судлын биетүүд илэрдэг. Дэл, судлын биетүүд нь ихэвчлэн зүүн хойшоо, хааяа хойшоо сунасан байх бөгөөд диорит, диорит-порфирит, кварцын диорит, плагиоборжин, жижиг ширхэгтэй боржин зэрэг фацын өөрчлөлтэйгээр талбайд тархана.

**Стратиграфийн хил зааг:** Заамар бүрдлийн гүний чулуулаг нь Заамар формацын метаморф хувирмал чулуулгийг түрж, түүнийг зүсч гарсан янз бүрийн хэлбэр дүрстэй гаршуудыг үүсгэнэ.


Гүний чулуулгийн гадаад хил заагт эвэр хуурмагжилт, кварцжилтын төрлийн хувирлыг үүсгэсэн байна. Кварцын судлууд нь алтжилттай болно. Районд алтны өндөр агуулгатай кварцын судал нэлээд өргөн тархацтай ба тэдгээрийн нас Заамар бүрдлийн гүний чулуулагтай холбоотойгоос гадна, зарим кварцын судал хожуу палеозойн магматизмтай гарал үүслийн холбоотой гэж тодорхойлогдсон байдаг. Кварцын судлын зузаан хэдэн сантиметрээс 2 м, заримдаа 4,0 м хүртэл хэлбэлзэх ба эгц уналтай (60-85°), нэг метрээс 800 м хүртэл урттай гэж тогтоогдсон. Алтны өндөр агуулгатай кварцын судлын биетүүдийн насыг Б.А.Блюман, В.В. Жданов, С.Цэрэн-Очир нар (1989) “Хойд Хэнтийн алтны хүдрийн бүсийн магмын ба метаморф-метасоматит бүрдлийн алтжилт” ажилдаа тусгажээ.

### ***Түрүү девон, Заамар бүрдэл (γ<sub>3</sub>D<sub>1z</sub>)***

**III-р фаз.** Интрузив нь Заамарын нурууны төв хэсгээр баруун урдаас зүүн хойш чиглэлтэй зууван хэлбэртэй биет үүсгэн тогтоно. Түрүү девоны Заамар бүрдлийн боржин нь дунд кембри-доод ордовикийн Заамар формацын хурдсыг зүсч, хойд талаараа миссисипийн Өрмөгтэй формацын тунамал чулуулгаар хучигдаж тогтсон байна. Уг массив нь агаарын гэрэл зурагт сааралдуу, сансрын зурагт бор хүрэн өнгө үзүүлэх ба бөмбөгөр оройтой мөлгөр гадаргуу үүсгэдгээрээ Заамар формацын хурдсаас ялгагдана. Интрузив чулуулаг нь биотит, амфиболтой, дунд-жижиг ширхэгтэй аляскит маягийн шүлтлэг боржингийн найрлагатай. Чулуулгийн гадаад хил зааг орчмоороо роговикжиж, кварцжсан хувиралтай.

## ПАЛЕОНТОЛОГИЙН СУДАЛГАА


Тус талбайд палеонтологийн хайгуул тандан судалгааг 10 ажиглалтын цэгт хийж, цэг бүрд координат авч, илэрсэн хурдас чулуулгийн товч бичиглэлийг хийн, фото зургаар баримтжуулан, амьтан ургамлын чулуужсан үлдэгдэлтэй эсэхийг магадлан, доор харуулав.



Зураг 8. “Ар Наймганы дунд хэсэг” нэртэй MV-005028 тоот (1252,6 га) ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд гүйцэтгэсэн палеонтологийн хайгуул, тандан судалгааны баримт материалын зураг


● Ажиглалтын цэг





Зураг 9. “Ар Наймганы дунд хэсэг” нэртэй MV-005028 тоот (1252,6 га) ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд гүйцэтгэсэн палеонтологийн хайгуул, тандан судалгааны ажиглалтын цэгүүдийн байрлал (Google Earth 2020 ).

АЦ 1: N 48°17'14.22" E 104°29'24.13"



Зураг 10 . Цэг нь Ар Наймганы хөндийд байрлах ба энд дөрөвдөгчийн хурдсын анхдагч байрлал алдагдаж, уурхайн үйл ажиллагаа явагдаж байгаа газар байна. Цаад талд нь өндөрлөг рельеф үүсгэж Заамар формацын хурдас тархана. Дөрөвдөгчийн хурдас нь Заамар формацын чулуулгийн хэмхдэс, бул, хайрга, сайрга бүхий элсэрхэг, шаварлаг хурдсаас бүрдэнэ. Палеонтологийн үлдэгдэлгүй.



**АЦ 2:** N 48°16'42.81" E 104°30'8.57"



*Зураг 11. Уулархан рельеф үүсгэж Заамар формацын метатунамал хурдас, харин хөндийгөөр нь плейстоцен, голоцений сэвсгэр хурдас тархана. Техникээр түрж, хөндийн хурдсын анхдагч байрлал эвдэгдсэн. Палеонтологийн үлдэгдэлгүй.*

**АЦ 3:** N 48°16'0.64" E 104°30'58.20"



*Зураг 12. Уурхайн зүүн хойд хана. Энд дунд-дээд плейстоцен, голоцений алюви-пролювийн гаралтай улаавтар хурдсын давхраасууд илрэх ба мөрөгцөгийн хана экваторын шанагаар маажигдсан, хусагдсан, эвдэрсэн тул хурдсын байдлыг ажиглах боломжгүй, палеонтологийн үлдэгдэл ажиглагдахгүй байв. Цаад талд нь Заамар формацын метатунамал тархана.*



*Зураг 13. Уурхайн урд, баруун урд хана. Улаан шаргал, шар саарал өнгийн алюви-пролювийн гаралтай элс, саарал өнгийн хайрганы үетэй улаавтар шавранцар, хайрганцар агуулсан элсэрхэг хурдсаас бүрдэнэ. Хананд ерөнхий ажиглалт хийхэд цухуйсан яс, үлдэгдэл ажиглагдсангүй. Хөрс хуулалт, ухах зэрэг уурхайн үйл ажиллагааны үеэр амьтны үлдэгдэл, яс шрэх болмжтой тул анхаарч ажиллах нь зүйтэй.*

**АЦ 4:** N 48°15'2.42" E 104°30'37.62"



*Зураг 14. Цэг орчимд Заамар формацын метатунамал хурдас тархана. Голчлон өндөр уулархаг рельеф үүсгэжээ. Энд ногоон, ногоовтор саарал өнгийн метатунамал-терригийн хурдас илэрнэ.*





*Зураг 15. Том ширхэгтэй, цул текстуртэй ногоон, ногоон саарал өнгийн элсэнчулуу илэрнэ. Гадаргууд элэгдсэн гаршууд тохиолдох ба палеонтологийн ямар нэг үлдэгдэл ажиглагдсангүй..*

**АЦ 5:** N 48<sup>0</sup>15'11.47" E 104<sup>o</sup>32'50.20"



*Зураг 16. Хараа группын доод Заамар формацын хурдас ба дөрөвдөгчийн хурдсын харьцаа. Хөндий хэсгээрээ ургамлын бүрхэвчтэй гарш илэрц муутай, гадаргууд голчлон сайрга, хайрганцар, хааяа эртний чулуулгийн томоохон хэмхдэс, бул агуулсан элсэрхэг хурдас илэрнэ.*





*Зураг 15. Цэг орчимд зарим газраа Заамар формацын метаэлсэнчулууныүндсэн гаршууд цухуйж илэрнэ. Хавтанлаг хэсэгшилтэй, цахиуржсан, хар ногоон, ногоон саарал өнгөтэй метаэлсэнчулуу байх ба палеонтологийн үлдэгдэл агуулаагүй байна.*

**АЦ 6:** N 48°15'26.75" E 104°31'59.51"



*Зураг 16. Цэг орчимд том ширхэгтэй, цул текстуртэй ногоон, ногоон саарал өнгийн элсэнчулуу илэрнэ. Өндөрлөгдүү рельеф үүсгэх ба нам хэсэгт гадаргууд элэгдсэн цухуйц гаршууд тохиолдоно. Палеонтологийн ямар нэг үлдэгдэл агуулаагүй.*



**АЦ 7:** N 48°16'35.34" E 104°31'3.44"



*Зураг 17. Дөрөвдөгчийн хурдастай хөндий. Голчлон элсэрхэг шавар, шавар, элсэнцэр илэрч байна. Анхдагч байдал эвдэгдсэн. Цаад талын өндөрлөг хэсгээр ногоон, хар ногоон, саарал, цайвар саарал өнгийн метаэлсэнчулуу тархах ба элэгдсэн мөлгөрдүү рельеф бүхий намхан толгод үүсгэж тогтоно. Палеонтологийн үлдэгдэлгүй.*

**АЦ 8:** N 48°17'31.75" E 104°30'30.03"




*Зураг 18. Энд саарал өнгийн голоцений хурдсаар хучигдсан улаан, улаавтар өнгийн плейстоцений хурдас уурхайн хайнанд илэрнэ. Эдгээр нь уулс хоорондох хөндийг дүүргэх ба гадаргууд илэрцгүй, зөвхөн доош ухсан тохиолдолд зүсэлтүүд илэрнэ. Хөндийн хоёр талаар Заамар формацын хувирмал тунамал хурдас уулархаг рельеф үүсгэн тогтоно. Өмнөх геологийн судалгааны ажлуудаар Хараа группын хурдсууд, түүний доод хэсгийг бүрдүүлэгч Заамар формацын хурдас чулуулгаас ямар нэг палеонтологийн үлдэгдэл илэрч байгаагүй.*

**АЦ 9:** N 48°17'42.29" E 104°29'54.60"



*Зураг 19. Ар наймганы хөндий. Адюви-прловийн гаралтай дөрөвдөгчийн хурдас тархсан. Цэг орчимд хөрс хурдас нь техникээр эвдэгсэн. Овоолгоос ажиглахад Заамар формацын болон палеозойн интрузив чулуулгийн хэмхдэс, хайргууд, хайрганцар бүхий элс, элсэрхэг, шаварлаг хурдас илэрнэ. Палеонтологийн үлдэгдэлгүй.*

**АЦ 10:** N 48°16'58.80" E 104°30'32.40"



*Зураг 20. Хурдас чулуулгийн үндсэн илэрцгүй дөрөвдөгчийн хучаас хурдас. Алсад уулсаар Заамар формацын хурдас тархана.*





**СТРАТИГРАФИ-ПАЛЕОНТОЛОГИЙН СУДАЛГААНЫ  
ТӨВ  
RESEARCH CENTER for STRATIGRAPHY &  
PALEONTOLOGY**



ШУТИС-ийн төв байр, 8-р хороо,  
Бага тойруу, Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар, Монгол улс  
Шуудангийн хайрцаг 46/520

Палеонтологийн хайгуул, судалгааны ажлын дүгнэлт

“Монгол улсын Иргэний хуулийн 343-358 дүгээр зүйлүүд, “Соёлын өвийг хамгаалах тухай” Монгол улсын хуулийн 2014 оны 5 сарын 15 ний өдрийн шинэчлэсэн найруулгын 38.1.2-д заасны дагуу Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг “Монгол майнинг энд эксплорэйшн” -тай ШУТИС, ГУУС-ийн Стратиграфи-Палеонтологийн судалгааны төв 2020 оны 10 сарын 8-ны өдөр “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулсны үндсэн дээр Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Ар Наймганы дунд хэсэг” нэртэй MV-005028 тоот (1252,6 га) ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн хайгуул тандан судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.


“Ар Наймганы дунд хэсэг” нэртэй MV-005028 тоот (1252,6 га) ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд дунд кембри-доод ордовикийн настай Хараа группын доод буюу Заамар формац ихэнхи хэсгийг эзлэн, дунд-дээд плейстоцен, голоцений настай алюви-пролювийн сэвсгэр хурдас Ар наймганы хөндий дагаж, силур-девоны Заамар бүрдлийн интрузив чулуулаг нь Заамар формацаа зүсэж бага хэмжээгээр тус тус тархсан байна.

Талбайд тархсан давхраат хурдас болох Заамар формац нь метаэлсэн чулуу, элсэн чулуу, аргиллит, алевролит, филлит, төрөл бүрийн занарууд, биотитот, биотит-эвэр хуурмагт гнейс зэрэг голчлон хувирсан чулуулгаас тогтох тул дотроо палеонтологийн үлдэгдэлгүй байв. Өмнөх геологийн судалгааны ажлуудаар Заамар формацын хурдас чулуулгаас болон Хараа группын бусад формацуудын хурдсаас амьтан ургамлын чулуужсан үлдэгдэл илэрч байгаагүй байна. Дөрөвдөгчийн хурдас нь голчлон алюви, пролювийн гаралтай хайрга, хайрганцар, элс, шавранцар, элсэнцэрээс тогтох тул дотроо палеонтологийн үлдэгдэлгүй.

Иймд “Монгол майнинг энд эксплорэйшн” ХХК-ны Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Ар Наймганы дунд хэсэг” нэртэй MV-005028 тоот (1252,6 га) ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд геологи хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг явуулахад палеонтологийн талаас харшлах зүйлгүй гэж үзэж байна.

Танай компани үйл ажиллагаандаа Соёлын өвийг хамгаалах тухай хууль захирамжийг хүндлэн сахиж, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж байгаад талархаж байна.

ШУТИС, ГУУС-ийн Стратиграфи-Палеонтологийн судалгааны төв  
Судлаач, доктор  
Судлаач, доктор



## ГЭРЭЭТ АЖЛЫГ ХҮЛЭЭН АВСАН АКТ

2020-11-23

Улаанбаатар хот

Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Монгол майнинг энд эксплорэйшн” ХХК-ны Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Ар Наймганы дунд хэсэг” нэртэй MV-005028 тоот (1252,6 га) ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд ШУТИС-ийн Геологи Уул Уурхайн Сургуулийн Стратиграфи-Палеонтологийн судалгааны төвийн судлаачид палеонтологийн хайгуул, тандан судалгаа явуулж, өмнөх геологийн судалгааны материалуудтай танилцсаны үндсэн дээр 33 хуудас, геологийн болон фото зураг 20, хүснэгт 1 бүхий тайлан бичив.

Уг тайлан нь гэрээнд заасан хугацаандаа, чанарын зохих түвшинд бичигдсэн болно.

### ХҮЛЭЭН АВСАН:

